



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 1150

Рашаант сум

Г Ажлын хэсэг томилох тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Цахим ангийн сургалтын ширээ сандалны материал худалдан авах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Болормаа (Төрийн сангийн мэргэжилтэн)

Нарийн бичиг: Ц.Мөнхзул (Сэтгэл зүйч)

Гишүүн: Э.Лхагвадолгор (ЕБС-ийн тогооч)

2. Дээрх ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Б.АЛТАНГЭРЭЛ